

**МОНГОЛ-ЗӨВЛӨЛТИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦЭЭР,
ТҮҮНИЙ ТҮҮХЭН АЧ ХОЛБОГДОЛ****Л. Хайсандай**

Өнө эртний түүхтэй монгол нутагт ардын хувьсгал ялж, эрх чөлөөтэй тусгаар тогтносон шинэ улс үүсэн тогтож байсан тэр үед манай нам, төрийг үндэслэн байгуулагч их жанжин Д. Сүхбаатараас «Манай Монгол Ард Улсын тогтнон мандахад дотоодын хүчин нь ард түмэн бөгөөд гадаад байдал дээр түшиг тулгуур нь Зөвлөлийн засагт Холбоот Улс мөн. Үүнээс өөр зам байхгүй»¹ гэж гэрээслэн хэлсэн энэ үг хичнээн утга учиртай, үнэн зөв болохыг монгол, зөвлөлтийн ах дүүгийн найрамдалт харилцааны 60 жилийн түүхэн замнал яруу тод илтгэн харуулж байна.

Энэхүү найрамдалт харилцаа, найрамдлын эхийг Монгол улс ба Зөвлөлт Холбоот Орос улсын хооронд байгуулсан 1921 оны хэлэлцээр тавьсан юм. Тэр үед шинэ нийгэм, шинэ амьдрал цогцлон байгуулах зам дээр гарсан тус хоёр орны хоорондын харилцааг албан ёсоор хуульчлан бататгах угтвар нөхцөл нэгэнт бүрэлдсэн байв. Уг харилцааны үндсэн зарчим, шинж байдал, хэтийн зорилт нь Орос оронд ялсан аугаа их Октябрийн социалист хувьсгал, түүний шууд нөлөөн дор Монголд ялан мандсан ардын хувьсгалын агуулга, мөн чанараас урган гарсан юм.

Чухамдаа Октябрийн хувьсгалаар мэндэлсэн зөвлөлт төр засаг үүсэж байгуулагдсан анхныхаа өдрөөс эхлэн олон улсын харилцаанд улсууд их, бага ялгалгүй харилцан бүрэн тэгш эрхтэй байх, бие биесийг хүндэтгэх зарчмыг тунхаглан биелүүлж, хаант Оросоос Монголд тулган хүлээлгэсэн эрх тэгш биш гэрээ, хэлэлцээрүүдийг хүчингүй болгож, мөн империалист гүрнүүдтэй Монголын талаар байгуулсан түрэмгий нууц гэрээнээс татгалзаж, монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцлийг халуун дотноор угтан дэмжсэн билээ. Бүр 1916 онд В. И. Ленин бичихдээ: «...Бид бол Монгол, Перс, Энэтхэг, Египетчүүдтэй ойртон нийлэхийг бүх хүчээрээ чармайх бөгөөд... ингэхийг өөрийн үүрэг, эрх ашиг гэж бид үзэж байна. Биднээс илүү дарлагдан хоцрогдсон эдгээр улс түмэнд..ардчилал, социализмд шилжихэд нь туслахыг бид хичээнэ»² гэжээ. Их Лениний энэ үзэл санааг зөвлөлт засгийн газар удирдлага болгон хувьсгалт монголыг талархан үзэж, эрх тэгш нөхөрсөг харилцаа тогтоох бодлого явуулсан юм. Энэ бодлогодоо монгол бол эрх чөлөөтэй тусгаар тогтносон улс байх ёсгой»³ гэдгийг иш үндэс болгосон билээ.

Монголын ард түмэн Зөвлөлт Орос улстай найрамдалт харилцаа, найрамдал тогтоон хөгжүүлэхийн шийдвэрлэгч угтвар нөхцөл нь МАХН үүсэж байгуулагдсан явдал юм. МАХН бүр анхнаасаа социализмын ууган орон-Зөвлөлт улстай жинхэнэ ах дүүгийн найрамдалт харилцаа тогтоож, хамтран ажиллахыг чин зорилгоо болгосон байна. Намын анхду-

¹Х. Чойбалсан. Илтгэл, өгүүллүүд. УБ., 1951, 1-р боть. 141 дэх тал.

²В. И. Ленин. Зохиолуудын 25 дугаар боть, 63 дахь тал.

³1921 оны ардын хувьсгалын түүхэнд холбогдох баримт бичгүүд (1917—1921) УБ., 1957, 36 дахь талд үзнэ үү.

гаар их хурлын шийдвэрт: «Зөвлөлт засагт Орос улсын үзэл бодлого нь олон түмэнд тус хүргэхээс өөр харшлах явдалгүй хэмээсэн нь туйлын үнэн болох тул эрхбиш үүн лугаа нөхөрлөж эдүгээ ба эцсийн их хэргийг бүтээвээс сайн болно»⁴ гэж нотлон заажээ. МАХН ардын хувьсгалын ялалтаас өмнө Лениний нам болон Коминтернтэй холбоо тогтоосон нь өөрийн оронд ардын шинэ засаг төрийг үүсгэж бэхжүүлэх, Зөвлөлт социалист улстай жинхэнэ нөхөрсөг харилцаа тогтоож хөгжүүлэх явдалд чухал ач холбогдолтой болсон юм.

Найрамдалт харилцаа, найрамдал хоёр орны хооронд тогтоож, гэрээ байгуулах өөр нэг чухал угтвар нөхцөл нь зөвлөлтийн улаан армийн, ангиуд монголын түр засгийн газрын хүсэлтээр хүрэлцэн ирж ардын журамт цэрэгтэй хүч хавсран зөвлөлт, монголын ард түмний нийтийн дайсан барон унгернийг бут ниргэсэн явдал юм. Энэ хамтын тэмцэл нь оросын ялгуусан ажилчин тариачид, монголын малчин ардын хоорондын ангийн интернационалч холбоо нэгдлийн бодит илрэл байв. Чухам ангийн энэ интернационалч холбоонд үндэслэж, монгол-зөвлөлтийн ах дүүгийн найрамдал, эрх тэгш харилцаа бүрэлдэн тогтох болсон билээ.

Хувьсгал ялсны дараахан ардын нам, засаг дэлхийн олон улс оролцон эрх тэгш найрамдалт харилцаа тогтоох чин хүслээ илэрхийлж «Манай Монгол улс...их, бага гадаад улсуудтай уулаас харилцан нэвтрэлцэж, найрамдлын явдлыг огт хэрэгсэхгүй гэх биш, гагцхүү аль нэг харилцан найрамдах этгээдийн доторхи бүх утга чанарыг нарийвчлан мэдвэл сая харилцах явдлыг үүсгэхийг эрмэлзэнэ»⁵ гэж зарлан мэдэгдсэн байна. Гэтэл тэр үед дэлхийн хөрөнгөтөн орнууд шинэ Монгол улсыг хүлээн зөвшөөрч, түүнтэй найрамдалт харилцаа тогтоох байтугай бүхий л талаар түүнийг дайсагнаж гадуурхаж байсан юм. Харин гагцхүү Октябрийн эх орон-Зөвлөлт Улс монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолд баяр хүргэж, найрамдлын харилцаа тогтоохыг урьдын адил хүсэж эрмэлзэж байгаагаа гадаадын улс гүрнүүдээс анх түрүүн албан ёсоор мэдэгдэж билээ.

Тийнхүү 1921 оны аравдугаар сард Монгол ардын нам, засгаас Д. Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэй бүрэн эрхт төлөөлөгчдийг⁶ айл хөрш хоёр орны ард түмний ангийн хувьсгалт хэлхээ холбоо, эв нөхөрлөлийг хуульчлан бататгаж, Зөвлөлт Орос улстай хэлэлцээр байгуулах зорилгоор Москвад томилон илгээжээ. 1921 оны аравдугаар сарын 26-ны өдөр эхлэж Монгол, Зөвлөлтийн засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчдийн хооронд явагдсан хэлэлцээний дүнд мөн оны арван нэгдүгээр сарын 5-нд Монгол Улс ба Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улс (ЗСБНХОУ)-ын хооронд найрамдлын харилцаа тогтоох тухай хэлэлцээр байгуулагдсан юм. Энэ хэлэлцээр нь манай хоёр орны болон олон улсын харилцааны түүхэнд үлэмж чухал ач холбогдолтой, хэд хэдэн онцлогтой юм. Үүнд: Юуны өмнө үг хэлэлцээрийг дэлхийн хөдөлмөрчдийн их багш, жолоодогч В. И. Ленин, монголын хувьсгалын удирдагч Д. Сүхбаатар нарын идэвх санаачлага, шууд оролцоотойгоор байгуулсан явдал түүхийн үнэт хишиг юм. Нэн ялангуяа энэ хэлэлцээрт гарын үсэг зурсан тэр өдөр их Ленин Кремль дэх албан тасалгаандаа Д. Сүхбаатар зэрэг монголын төлөөлөгчдийг хүлээн авч уулзан нөхөрс-

⁴МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. Нэгдүгээр дэвтэр. УБ., 1966. 28 дахь тал.

⁵Ардын засгаас 1921—1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд (Баримт бичгийн эмхтгэл), УБ., 1954. 38 дахь тал.

⁶Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Намын Төв Хорооны дарга Данзан, Гадаад явдлын яамны дэд сайд Б. Цэрэндорж, Эрдэнэ жонон ван Ширнэн-Дамдин, Монголын төлөөлөгчдийн нарийн бичгийн дарга Даваа, төлөөлөгчийн орчуулагч, ардын засгийн газрын хэргийг эрхлэгч Эрдэнэбатхаан нар оролцжээ.

гөөр ярилцсан нь онцгой тэмдэглэлтэй үйл явдал болсон билээ. Энэхүү уулзалтыг үнэлж нөхөр Л. И. Брежнев хэлэхдээ: «Манай найрамдлын түүх шашдирт яруу алдарт хуудас олон бий. Гэхдээ Владимир Ильич Ленин, монголын хувьсгалын жолоодогч Сүхбаатартай учран золгосон түүхт уулзалт бидэнд юу юунаас дотно байдаг»⁷ гэж онцлон тэмдэглэсэн байна.

В. И. Ленин монголын төлөөлөгчдөд хандаж «...хоёр этгээд эрх ашиг хувь тэгш гэрээ бичиг байгуулсан тул үүнээс хойш бидний Орос, Монгол хоёр этгээд улсын хувиар бол зэргэлдээ улсын адил, нөхрийн хувиар бол ах дүүгийн адил найрамдан явбал зохино»⁸ гэж өгүүлсэн байна.

Манай төлөөлөгчидтэй уулзах үеэр аугаа их Ленинээс өгсөн үнэт сургаал, зөвлөлгөө нь Монгол Ард Улс, ЗСБНХОУ-ын хооронд байгуулсан найрамдлын хэлэлцээрийн 60 жилийн ойн тухай МАХН-ын Төв Хорооны тогтоолд зааснаар «...монголын ард түмний хувьсгалт ололтыг бэхжүүлэх, хоёр орны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, шинэ Монгол улсыг нийгмийн дэвшлийн замаар хөгжүүлэх талаар МАХН, ардын засгийн газрын бүхий л үйл ажиллагааны удирдлага болсон юм» **Хоёрдугаарт:** Энэ хэлэлцээр нь ардын эрхт шинэ монгол улс тусгаар тогтнон биеэ даах хөгжлийн замд дөнгөж гарч байсан нарийн эгзэгтэй хүнд бэрх бөгөөд нэн хариуцлагатай үед байгуулагдсанаараа онцлог, ач холбогдолтой юм. Тийнхүү энэ хэлэлцээр нь манай улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол болон цаашдын хөгжил цэцэглэлтийн найдвартай баталгааг бий болгосон билээ. **Гуравдугаарт:** Энэ хэлэлцээрээр манай хоёр улс бие биесийнхээ засгийн газрыг хууль ёсны засгийн газар мөн гэж харилцан хүлээн зөвшөөрөөд тус тусын оронд бүрэн эрхт төлөөлөгчид ба консулыг солилцон суулгахаар тогтжээ. Мөн хэлэлцээрийн оршил хэсэгт заасанчлан тус хоёр орны нэгд маань ажилчин-тариачны анхны төр-Зөвлөлт засаг, нөгөөд маань ардын эрхт шинэ засаг нэгэнт тогтсон учир үүний өмнө нэг нь нөгөөдөө хүч хэрэглэн байгуулсан аливаа эрх тэгш биш гэрээ хэлэлцээрүүдийг цуцалж цаашид дагаж мөрдөхгүй байх учрыг зарлан тунхаглажээ. Энэ бол манай хоёр улсын хоорондын байгуулсан анхны хэлэлцээрийн улс төрийн гол шинж, үзэл санаа, үндсэн агуулга юм. Өөрөөр хэлбэл дарлал мөлжлөг, тэгш бус байдалд тулгуурласан хуучин харилцааг бүрмөсөн халж, жинхэнэ адил тэгш эрхийн үндсэн дээр суурилсан цоо шинэ харилцааг үүсгэн тогтоож, айл хөрш манай хоёр орны ард түмний олон үеийн уламжлалт болон шинэ цагийн ангийн хэлхээ холбоог анх удаа хуульчлан бататгасанд уг хэлэлцээрийн нэг чухал онцлог, түүхэн ач холбогдол оршино. **Дөрөвдүгээрт:** Хэлэлцээрт харилцан эрх тэгш байж, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэж бие биеийн дотоод хэрэгт үл оролцох, харилцан туслах, эдийн засгийн талаар биеэ даасан байдлыг хангах, харилцан ашигтай ах дүү, нөхөр ёсоор хамтран ажиллах зэрэг пролетарийн интернационализмын үзэл санаа, зарчим тод томруун тусгалаа олсон байна. Нөхөр Ю. Цэдэнбал бичихдээ: «Эдгээр зарчмыг олон улсын харилцааны түүхнээ чухамхүү Монгол улс, Зөвлөлт Орос улс хоёрын харилцаанд л анх түрүүн тунхаглаж 1921 оны арван нэгдүгээр сарын 5-нд тус хоёр орны хооронд байгуулсан найрамдалт харилцаа тогтоох тухай хэлэлцээрт илэрхийлсэн нь маш тэмдэглэлт зүйл юм»⁹ гэжээ **Тавдугаарт:** Энэ хэлэлцээр нь ардын эрхт шинэ монгол улсын хувьд гадаадын улс гүрэнтэй биеэ дааж байгуулсан анхны тэгш эрхтэй гэрээ байлаа, «Бү-

⁷«Үнэн, 1974 оны 11 дүгээр сарын 27.

⁸В. И. Ленин. Монголын тухай. УБ., 1969. 77 дахь тал.

⁹Ю. Цэдэнбал. Социалист монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал. УБ., 1976. 497 дахь тал.

рэн тэгш эрх, чин үнэнч нөхөрлөлийн зарчим дээр үндэслэсэн ийм хэлэлцээг Монгол улс тэр үед тус орныг эрх чөлөөт тусгаар тогтносон бүрэн эрхт, хөгжин цэцэглэж байгаа улс байлгахыг үргэлж эрмэлзэж байсан ганцхан зөвлөлт засгийн газартай байгуулж болох байв»¹⁰ гэж нөхөр Ю. Цэдэнбал дүгнэн тэмдэглэжээ. Мөн түүнчлэн тус хэлэлцээр нь шинэ тулгар ардын төрийн гадаад байдлыг бэхжүүлж, түүний нэр хүнд, байр суурийг олон улсын тавцан дээр улам өсгөн нэмэгдүүлэх, империалист гүрнүүдийн ялгаварлан гадуурхах түрэмгий бодлогыг тухай бүр няцааж байх жинхэнэ бололцоог олгож өгсөн юм.

Зургадугаарт: Түүхт энэ хэлэлцээрийн өөр нэгэн чухал онцлог, ач холбогдол гэвэл БНМАУ, ЗСБНХУ-ын ах дүүгийн найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны болон нийгмийн амьдралын түүхэн бүх үйл явцад тэр нь тодорхой үе шатуудыг дамжин үргэлжилж, улам баяжиж, аль ч талаараа улам боловсронгуй болж хөгжин батжиж ирсэнд оршино. Уг хэлэлцээрийн үзэл санаа, зарчим 1929 оны «БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын харилцааны үндсэн зарчмын тухай» хэлэлцээр, 1936 оны «БНМАУ, ЗСБНХУ-ын харилцан туслах тухай» протокол, 1946 оны «БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд найрамдалт харилцан туслах тухай гэрээ, «эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай» хэлэлцээр, 1966 оны «БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслах тухай» гэрээ зэрэгт гүн гүнзгий тусгал хөгжлөө олж бататгагдсан юм.

Тийнхүү эдгээр түүхт гэрээ, хэлэлцээрүүд нь шинэ монгол улсын эрх чөлөө, тусгаар тогтнолыг бататган бэхжүүлж, аюулгүй байдлыг хангаж, манай нийгмийн урагш давшин хөгжих ширгэшгүй эх ундаргын найдвартай баталгаа болж ирсэн ба болсоор байна.

Монголын ард түмэн социализмын ууган орон, зөвлөлтийн ард түмэнтэй тогтоосон харилцаа, найрамдлаа ардын хувьсгалын аугаа их ололт, МАХН, ардын засгийн гадаад бодлогын тууштай зөв мэргэн чиг шугамын ялалт, их Лениний үзэл санааны бодит биелэл, манай эх орны үнэт баялаг гэж бахархан хүндэтгэж үздэг юм.

Тууштай ленинч, манай ард түмний их анд нөхөр Л. И. Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид БНМАУ-д айлчлах үеэр 1966 оны нэгдүгээр сард тус хоёр орны хооронд найрамдал, хамтын ажиллагааны болон харилцан туслах тухай Гэрээ байгуулагдсанаар монгол-зөвлөлтийн ах дүүгийн харилцааны хөгжлийн шинэ дээд үе шат эхэлсэн юм.

Ийнхүү дайны хүнд бэрх үед ч, энх тайван цагийн нөхцөлд ч амьдралын аливаа шалгалт сорилтыг амжилттай даван туулсан тус хоёр орны ард түмний жинхэнэ ах дүү ёсны уламжлалт найрамдал, БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын харилцаа, тал бүрийн хамтын ажиллагаа жилээс жилд цар хүрээгээрээ өргөжин тэлж, агуулга хэлбэрээрээ баяжин гүнзгийрч, хөгжин цэцэглэж байна.

Манай нам, төрийн гарамгай удирдагч Ю. Цэдэнбал Зөвлөлт Холбоот Улстай тогтоосон манай найрамдлыг социалист интернационализмын биелэл гэж тодорхойлсон юм.

БНМАУ феодализмаас социализмд түүхэн шилжилт хийж, капиталист биш хөгжлийн замын ээдрээтэй нарийн зорилтыг бүрэн төгс шийдвэрлэсэн хийгээд манай ард түмний амьдралын салбар бүхэнд гарсан гүн гүнзгий социалист өөрчлөлт, ололт амжилт нь Октябрийн өлгий-Зөвлөлт Холбоот Улстай тогтоосон найрамдалт харилцаа ах дүүгийн найрамдал, түүний сэтгэл харамгүй тусламж дэмжлэгийн цаглашгүй ач холбогдлыг өнөө үед яруу тод илтгэн харуулж байна.

¹⁰Ю. Цэдэнбал. Илтгэл, өгүүлэл, хэлсэнүг. II боть, УБ., 1967. 125 дахь тал, УБ., 1976. 551 дэх тал.

ПЕРВОЕ МОНГОЛО-СОВЕТСКОЕ СОГЛАШЕНИЕ И ЕГО ИСТОРИЧЕСКОЕ ЗНАЧЕНИЕ

(Резюме)

Л. Хайсандай

Первое соглашение заключенное Монголией с Советской Россией, по своему содержанию и целям явился первым в международной практике образцом отношений нового типа. Возможность подписания такого соглашения появилась только после победы Народной революции в Монголии которая произошла под влиянием Великой Октябрьской революции.

Решающим фактором, обусловившим установление дружеских отношений с Советской Россией, явилось наличие и образование Народной Революционной партии Монголии. В решениях I съезда партии подчеркивалась необходимость установления дружеских связей с Советской Россией. Тесная связь Народной партии Монголии с Коминтерном и РКП (б) еще до победы революции в Монголии сыграла важную роль в образовании и укреплении Народного правительства нашей страны.

Взаимные интересы народов Советской России и Народной Монголии, объединенных общей целью борьбы за построение нового общества, против угрозы мирового империализма, привели к формированию и укреплению межгосударственного союза рабочего класса СССР и монгольских аратов. Соглашение, открывшее новую страницу в летописи дружбы и сотрудничества народов наших двух стран, как отмечал тов. Ю. Цеденбал, послужил началом утверждения в международном плане новых социалистических отношений, основанных на принципах подлинного равноправия и взаимного уважения, братского сотрудничества и взаимопомощи.

На прочной основе этого исторического Соглашения с каждым годом неуклонно крепла братская дружба между народами МНР и СССР, все более расширялось и углублялось их тесное всестороннее сотрудничество. Об этом свидетельствует вся история монголо-советских взаимоотношений.

Идеи и принципы Соглашения 1921 года развиты и обогащены в таких исторических документах, как в Соглашении 1929 г. об основных принципах взаимоотношений между МНР и СССР, Протоколе 1936 г. о взаимной помощи, Договоре о дружбе и взаимопомощи и соглашении об экономическом и культурном сотрудничестве между МНР и СССР от 1946 г., а также в Договоре о дружбе, сотрудничестве и взаимной помощи от 1966 г., который отражает новую, более высокую ступень развития отношений между двумя странами.

Можно с уверенностью утверждать, что переход от отсталости к прогрессу наша страна совершила только в тесном сотрудничестве и при всесторонней помощи и поддержке первого в мире социалистического государства-Советского Союза.